

МОНГОЛ ДАРХНЫ ХИЙЦ ДҮРСЛЭЛИЙН ОНЦЛОГИЙГ
ТОДОТГОХ ЗАРИМ БАРИМТ

Ч.Болдбаатар¹
Д.Энхдаваа²

Дархны урлал XVIII-XIX зууныг дамнахдаа нүүдэлчдийн ахуй, хэв галбираа хадгалахын зэрэгцээ бурхан дүрслэлийн номлолыг өвөрмөцөөр баяжуулж хөгжүүлсэн баримт нэлээд байна. Энэ нь шар хар феодал хийгээд чинээлэг хүмүүс өөрийн чадал тэнхээгээ харуулахын тулд нэртэй дархчуулаар хүрээлүүлж тэдний хийсэн эдлэлийг хэрэглэхийг эрмэлзсэнтэй холбогдоно. Нөгөөтэй томоохон хүрээ хийдийн дэргэд лам, авъяаслаг урчуудыг хамарсан дархны дэг сургууль төвлөрч байлаа. Дархны ур эрдэмд боловсорсон лам нар “Махаяна”, “Хинаяна” хөлгөн ухаанаас суралцаж харь хэлээр ном зохиолоо бичсэн нь гар урлалын хийц дэг чиглэлтэй, төрөлсөн байдлаар салбарлахад ихээхэн нэмэр болжээ. Ялангуяа Цахар гэвш Лувсанчүлтэм утгыг гүйцэд илэрхийлэн яруу байхыг учирласан олон зохиол тэрлэсний дотор ур хийц чимгийг хэмжээ харьцаа, хот мандалын тигээр тайлбарлаж оноосон ойлголт шинжлэлээр шаштирласныг тэмдэглэх нь зүйтэй. Манай номч мэргэд эртний Энэтхэг, Түвдийн тиг хэмжээ, харьцааны учир холбогдлыг түүвэрлэн судлаж тэр үндсэн дээр гарын авлага, ном судар барласнаас “Ишбалжирын зохиосон «Бие, зарлиг, сэтгэлийн шүтээний тиг, хэмжээний үндсэн ба тайлбар зүүлт, цэцгийн үзэсгэлэнт эрх», Ролбидоржийн бичсэн «Урлахуй ухааны нэр» толь...»³ зэрэг онолын шинжтэй бүтээл зохиол олныг туурвисан байна.

Гэхдээ дархны сор хийц дүрслэлийг илтгэх зарим дурсгалыг судлаж үзэхэд дан ганц шашны ур дэмийн чиглэл хандлагатай байсангүй. Хэрэглээний үүдэлтэй урлал гэмээр Батноров хийц, Далайчойнхор хийц, Ноён сэврээ хийц, Дарьганга хийц, Боржигон хийц гэхчилэн ялгарах боловч ерөнхийдөө овор төрхөөрөө нийтлэг үндэстэй, ардын язгуур соёлыг хадгалсаныг баримтаас харж болно. Тэр үеийн төрөл бүрийн төмөрлөгөөр хийсэн содон дурсгалд эдэлгээг илүү анхаарч урласан хийцтэй байдаг. Үүнийгээ ч магадласан мэт Дагвадорж, Цэвээнжалба, Шар, Хондог, Тожил, Ерэнтэй, Самбуу, Чавганц, Бага шар, Шаравжамц, Самдан, Бөгтөр, Лувсандагзан тэргүүтэй алтан гартны бүтээл төв, орон нутгийн музейн урын санд багтаж гайхамшигтай ур галбир нь ихээхэн судлагдсаныг тэмдэглүүштэй⁴.

¹ Доктор, дэд профессор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль

² СУИС-ийн Дүрслэх урлагийн сургууль

³ Цүлтэм Н. (1988. 73) Монголын уран зургийн хөгжиж ирсэн тойм. УБ.,

⁴ DSCHINGIS KHAAN und seine erben (герман.2006), Die Mongolen. (герман.1989), Great Mongolia (япон.1992), The Ancient Culture of Mongolia (солонгос. 2008), Tresors de Mongolie (франц.1993), Genghis khan-The Ancient Nomadic

Тухайлбал, хүрээний нэртэй цутгуурчдаас Халиуны Дагвадорж нь сангийн бойпороо чандмань тулгууртай, тагийг цэцгэн хээгээр чамин цоолборлон бүтээжээ. Уг бүтээл нь Хятадын Инь гүрний цутгуурыг санагдуулам битүү хийцтэй мөртөө зааныг урласан овор төрхөөрөө Жагарын урлалыг эзэмшсэн барилтай. Түүний бойпорт нууц тариний үйл, эрхэмлэл бүхий сэдэл давхар илтгэгдэнэ. Бойпорын тулгуураа Чинтамуни буюу “сэтгэлчлэн бүтэх” гэх онжадаар, хүнхээг усан мандалын сараан цэцгэс шигтгэн чимэглэжээ. Дүрслэлд утга тайлал хийвээс, нэгд; чинтамуни эрдэнийн хүчээр муу юмыг арилгаж, хоёрт; далдын хорлолыг нэвтрүүлэлгүй, гуравт; ариусалд хүрч хамаг хүсэл биелэх номын шидтэй гэх тариний мөр уншигдана. Хэрэв таван цогцод тулгуурлабал “норов” хэмээнэ. Тэрхүү норов буюу таван хүслийн үзүүрт харах буюу толь, сонсох буюу лавай, аягатай дарс буюу үнэртэх, аягатай жимс буюу амтлах, хив хадаг буюу хүртэхүйн үүдлийг нууц тэмдэг бий. Давгадоржийн бүтээсэн “хувиласан дүр” (персонаж) бүрийн өгүүлэмж нь үйл явдлын холбоосоор бус чухамдаа билиг билгүүний чандад хүрч гэгээрхүйн номын хэлхээсээр танигдах хувьтай. Тиймээс амьтны төрхөд хувилгасан дүр ёслол тарнийн тодорхой утга, зан үйлийн зориулалтыг агуулдаг. Бойпорын тулгуур буюу номын зарлигийг гүйцэлдүүлэгч нь “заанд” хувиран цэцэн ухааныг бэлгэшээх бөгөөд мөнхөд оршино гэх ёгтлолыг (аллегорик) давхар хэлнэ. Энд тайлбарлаж байгаа утга бэлгэдэл бол бурхны нууц тариний номын хүрдэнг монгол дархан хэрхэн ухаарч онжад санааг яаж галбиршуулсныг харуулах зөвхөн нэг л тайлал дүрслэлд холбогдох бөлгөө (Зураг 1).




Зураг 1.

1. Х.Дагвадорж. Сангийн бойпор. (хүрээ хийц)
2. Сангийн бойпор. (өндөр-Н 20.2 см, өргөн-В 15.3 см)
3. Сангийн бойпор. (өндөр-Н 25 см, Dm 18 см)

Харин Түнхээгийн Шар мөнгөн бойпороо урлахдаа их биеийг хэлбэж, ёроолыг цулгуй үлдээсэн атлаа бөөрний хээг гүн товойлгон, амсарын хээг хотгойлгон ингэмэлдэн шугаман цантиг хэрэглэжээ. Түүний барил гэвэл, бойпорын бариул чихийг хөөхдөө

Culture of the Northern China (хятад.2004), Mongolia museum highlights (америк.2005), Cengiz Han ve Mirascilarl (турк.2006), The Great Mongol Empire (япон.1992)

овор галбирыг нь цутгуураар үйлдсэн мэт товойлгож, чимэг хээг давтсан мэт хэмнэл зурлагаар загварчилжээ. Шар дархны бойпорын хээ чимэг тэгш хэмтэй тун цэгцтэй зурлагатай хөөсөн харагддаг нь тигдээ оршино. Иймд түүний бүтээсэн бойпорын хамар угалзны цантигаар байгуулж үзье. Тэгш дөрвөлжийн (ABCD) голч оройн босоо шугамаас (MM) суурийн хөндлөн шугамын (AB) өнцөг дэх цэгт (A,B) “сүр” татах учиртай. Үүгээр AM, BM ташуу хэрчмүүд байгуулагдана. Сүр гэдэг нь ташуу шугам бүхий байгуулалт. Удаагаар хажуугийн босоо шугамын голчийг (NN) C, A цэгтэй холбон татахад CN, NA гэсэн шугаман байгуулалтууд үүтнэ. Эл байгуулалт нь AM, BM хэрчмийг огтолсноор хээ чимгийг байгуулах тигийн үндсэн харьцаа хэмжээг, F_1M ф F_1A буюу $5\phi 1$ гэх тиг (модуль), түүнчлэн F_2M ф F_2B буюу $3\phi 2$ харьцаат тиг үүсдэг. Ийм шугаман тиг нь эвэр угалзны хөдөлгөөн болоод зурлагын эргэлэг бүрийн байгуулалтыг улам тодотгосныг бүдүүвчээс харахад мэдрэгдэнэ (Зураг 2.а).



Зураг 2. а 1. Тиг байгуулалтын тавтын харьцааны нэгж хэмжээс
2. Хээний цантигийн тигийн шугаман байгуулалт

Тиг бол үндсэндээ урлахуйн бүхий л арга барилд хэмжээ харьцааны олонлог хамаарлыг цогцлоосон хураангуй томъёолол юм. “Цан”- босоо шугам, харин “цантиг”- оройн шугамын байгуулалт гэсэн утгатай. Ер нь хээ зурлагын эхийг тиглэн бүтээх арга монгол дархчуулын дунд их дэлгэрснийг магадлах уг баримт багагүй байдгийг дээрх жишээ харуулна. Дархны ажилд хээ зурлагын зохист харьцаан дээр ур хийцийн гайхалтай шинж сууж бүтээгдсэнийг бас харж болно. Бойпороо тигш хэмийн зарчмаар тэнцүү давтамжтай урласнаас бүтээц нь бүхэлдээ “тайван” (тогтвортой, хөдөлгөөнгүй...) байдлыг илэрхийлдэг тал буй. Хээний чуулбар нь эдлэлийн чимэг төдийг биш харин хүний сэтгэл хөдлөлийг барихын тухайтад өгүүлэх явдалтай. Энэ нь хүрээнд нэрд гарсан Чойнхорлин аймгийн Доржийн “нэг цүн” дотор мянган заан дүрсэлдэгээс илүү чимхлүүр ур дэмийг агуулсан ойлголт болохоор хүний дотоод сэтгэлийн хөдлөл агшинг хээ чимэг сэлтээр зөөлрүүлж гэгээрүүлэхүйн хүч чадлын эрдэмд хуучны дархчуул мэргэжсэнийг давхар магадлах авай. Ягтаа “хүрээ” (номод шүтэхүйн) тавилтад хээ чимэг сэлтээр дамжуулан шашны номын ухааныг цэцлэх бөгөөд аливаа эдлэл дархлах буюу цутгах, сийлэх, зүсэх аргатай хосолж байж сая хийц тодордог нь зүйн хэрэг билээ. Бойпорын хийц чимэг нь хэмнэлийн тогтсон давтамжыг загварчлах байгуулалттай мэт боловч чухамдаа хээний зурлага сүлжээсийг дагнааст хэрхэн галбиршуулсаныг мэдрүүлдэг далд увидастай юм. Шар дархны барилыг гэхэд түвдийн дэгтэй холбон тайлбарлах нь зохистой санагдана. Түвдийн зохиомжийн зарчим гэвэл, төв дунд нь гол өгүүлэмжийг авч түүнийг тойруулан удаах сэдлийг дүрслээд, доорд тулгуурт номын зарлигийг гүйцэлдүүлэгчийг буулгадаг дэгийг барьдаг. Тухайн дэгийг манай дархчуулын, зарим нэр нь үл мэдэгдэх дархны урласан бойпорт бэлхэнээ харагдах бөгөөд бурхан дүрслэлийн талыг зайлшгүй нягтлан судлууштайг хэлье (Зураг 2 б).




Зураг 2. 6

1. Түнхээгийн Шар. Сангийн бойпор, мөнгө. (хүрээ хийц)
2. Нэр нь үл мэдэгдэх дархан. Бойпор (өндөр-Н 22 см, Dm 13 см)

Монголын гар урлалын олон янз барил дотор хэрэглээнээс үүдэлтэй эдлэлийг гаргууд дархалдаг “Батноров” хийц нэлээд ялгавартай. Тэд мөнгөөр цутгаж бэлдсэн эмээлийн тоногоо тэшлүүрээр засаж хаждаг нь тохиолдлын ажиллавар бишээ. Батноровын мөнгөөр дархлах ур үйлийг судлахгүйгээр Цэцэн хан аймгийн урчуудын дүрслэлийн онцлогийг тодруулах боломжгүй. Барилд хэлбэрших гол онцлог гэвэл, хээний зурлага цохилгоо голцуу эвэр угалз барьж цутгахдаа давтамж хэмыг толин тусгалаар биш харин сөөлжүүлсэн байршилаар сүлжин тиглэдэг байна. Удаах бас нэг онцлог гэвэл, мөнгөний зуурамтгай шинж горимыг (таван лан мөнгөнд нэг лан гууль) баримталсан цутгуурын хэвээ “цой” загварт буй эвэр угалзны эргэлгийн дагуу ч орон зайн шийдлээ зөвхөн хажиж зааглан урладаг содон хэллэгтэй байгаа юм. Чухам эдгээр онцлог хэллэг бүхий ингэмэл цутгуураа эргүүлэн засаж цоолборлон, аль болохоор гол дүрсээ хажаар хязгаарлаж ихэнх тохиолдолд өндөр мандаатай баавар урладаг хандлага Батноров хийцэд дийлэнх байдаг. Ийнхүү Батноров дэгийн дүрслэлийн онцлог болоод урын талаас тайлбарлах явдал өмнөх судлаачдын ажилд огт тэмдэглээгүйг хэлэх нь зүйтэй. Цутгуур үйлддэг оворот ингэмэлийн гаргалга дүрсийн шугаман байгуулалтын үндэстэй тул хээний нэг л хэсгийг хувилган давтахдаа цой буюу эх зохиодгийг бас л нягтлан үзүүштэй санагдаж байна.

Иймээс бид, дархчуулын цутгуур ажиллаварыг тоочилгүй биет дурсгалтай (баавар, даруулга, товруу тоног) харьцуулан орон зайн болон дүрслэлийг бичвэржүүлэх, гол дүрсийн байгуулалт нь хажаас гаднах орон зайн тиг зурлагатай яаж зохирч буйг судлах шаардлага байна. Батноров хийц нь дүрсийн элементийг онцлож хээний сүлжээсийн оролт гаралтаар галбираа тодотгох хэв шинжийг анхаардаг төдийгүй нэгэн хавтгайд нэг л товч “эхээ” (цойг) давтсан нугалбарыг овор эзэлхүүний ойлголт болгодог тал бий. Монгол дарханд эзэлхүүн нь өрнөдийн урлалын хэрэглэдэг гурван хэмжилт (параметр тоо) бүхий оврыг хэрэглэдэггүй. Харин хээ угалзны зурлагын тоглолыг “цой” загварт буулгасан нугалбар оронтын ойлгоцоор чимгийн тигийг бүтээдэг байж. Энэ нь хээний зурлагын хажуу бөөрийг дүрслэлгүй харин эгц

дээрээс төсөөлөх орон зайн тохироо мөн байна. Үүнийг судлаач Ч.Болдбаатар орон зайг дүрслэх перцептив алслалын арга гэж нэрлэсэн байдаг. Эртнээс нааш орон зайг тусгах перцептив буюу төвт тусгалын хүртэхүй мэдрэмжтэй нь Батноровын дархны хийцэд ур болж үлджээ. Энд баримт болгосон Тожилын эмээлийн тоног, түүний хээ чимгийн зурлага ч гэсэн эгц дээрээс харсан буюу нэг “плант” мэт сэтгэгдэл төрүүлэм авч хаж хүрээгээр орон зайгаа ялган хязгаарласныг анзааралгүй орхиж боломгүй. Баримтыг харьцуулбал, хүрлийн үеэс уламжилсан дархны урлалд хэв ашиглан цутгах туршлага байвч горви хувилтай ажиллаварыг хэвдээ огт хэрэглэлгүй заншсан байхад Батноров хийцэд гох, түгжээгээр барахгүй хээний сүлжээсээ нэгийг нөгөөгөөр даруулсан мэт ухлаадасыг шавар хэвдээ шийдсэн байдаг. Нэг ёсондоо уламжлалт дархны урлал чулуу, шавар хэвэнд дулдуйдаж байхад (цутгасанаа засварладаггүй), Батноровын дархцуул хэвэнд баригдалгүй цутгуур заслагаа дараалалтай (цоолборлох, тэвшүүрлэх, хажих, гагнах г.м) гүйцэтгэж улмаар туурга мандаатай ширээж гагнаас үйлддэг ажиллавараар баяжуулж тогтсон барилыг эвдсэн байгаа юм. Ягтаа “цой” (эхийг) байгуулсан дэвсгэр ухлаадас болоод хээ хоорондын харьцаа нь нэлээд содон ажиглагддаг. Хээ, ухлаадасын харьцаа бараг 1ф1 хэмжээстэй, түүний эргэлзгийг эсрэг тэсрэг чигтэй (буюу төвд нэгдэх, төвөөс задрах) урлажээ. Хэдийгээр хээний байгуулалт тэгш хэмтэй мэт боловч өрөлт нь хэсэг хэсгээрээ тэгш бус (ассиметри) сөөлжсөн байрлалтай хэмнэгдэж буй нь байгуулалтаас ажиглагдана. “Цой” гэдэг бол мод буюу лаваар хийгдсэн цутгуурын эхийг оноосон нэр. Тожилын хийсэн эмээлийн мөнгөн даруулга, түүний хүрээ хажны доторхи угалз сүлжээсээ эвэр сэлтийн хөдөлгөөн чагтан зөрлөгтэй хослуулан давтжээ. Тожилын урласан эмээлийн тоногийн хувилбар бүрт (даруулга, баавар, ганзаганы сүвэгч) нэг л тогтсон жаягийг дагасаар байгаа нь хавсраг урлалын үндсэн шинжтэй. Ерөөс хээ угалзны зурлагын сүлжээсийг толин тусгалын давталтыг эвдэж тиглэдэг нь сонирхолтой бөгөөд эргэлгийн хөдөлгөөнөөр нэгдэх сарнихын (сайн муу) сурталыг бэлгэддэг тал ч байдаг. Магадгүй, Тожил “Чагтан сүлжээсээрээ” төрөх үржихийн ёр, ерөөлийг зөгнөснөөс түүний ийм тоногийн хийц халх даяар алдаршин дэлгэрсэн байж мэднэ (Зураг 3).



Зураг 3.

Тожил. Эмээлийн тоногны тогтсон тигийн шугаман байгуулалт, (арван цагаан) мөнгө, 1182,0 гр. Монгол улсын эрдэнэсийн сан (батноров хийц) 1. Даруулга, 2. Ганзаганы сүвэгч 3. Баавар

Тожилын хийц урын онцлогийг харуулах өвөрмөц зүйл бол ажиллавараар засаж чимэглэх арга байдаг. Өөрөөр хэлбэл, түүний урлалд хээ зурлагын бүтэц, түүний галбирын үелэл, тэнцэтгэлийн тохирооноос гадна орон зай, цутгуурын арга, хэвний жор, зүсэх, тэгшлэх, хажих зэрэг олон төрөл ойлголтыг өгүүлэхгүй орхиж болохгүй гэсэн үг. Иймд хээ галбирших орон зайг гол шинжээс (параметр тооноос) нь хамаарсаныг шинжих ёстой болно. Дархны урлалд хоёр хэмжээст, гурван хэмжээст гэж ухагддаг нь орон зайн хэмжилт параметрийн тооноос хамаарсан хэрэг. Харин Тожилын урласан эмээлийн тоногийн хээн ингэмэл хэдийгээр овортой харагдаж байвч гурван хэмжилтэт эзэлхүүний шинжгүйгээрээ онцлог. Гэтэл хэв бүтээх жорын хувьд нь анхаармаар зүйл байдаг. Тухайлбал, ангилсан наанги шавраа яаж шүүж, хэрхэн хужиржуулж түүндээ ямар хэмжээтэй зунгаг хольж хэв барих үйлийг хэлээд байгаа явдал юм. Үүнд хоёр гол жор ноёлдог. Эхнийх нь цутгуурын хэв бүтээхэд зунгаага ихдүүлбэл арзайж хэлбэр тогтохгүй буюу хэвшихгүй байх, удаах нь зунгаг багадаас нягт тогтохгүй буюу хагарах бартагтай байхыг хэлдэг. Батноровын цутгуурын урлалд хэвээ бэлдэхдээ нутгийн шороог буюу хар модны дархины саарал шороог онцолдог нь бас л нягт болгохын үүдэлтэй холбогдоно. Үүнтэй уялдаад цутгуурын аргыг ч ярих нь зүйтэй. Тожилоос аваад Цэцэн хан аймгийн олонхи дархчуул цутгах эдлэлийн овор хэлбэрээс хамаараад янз бүрийн аргаар хэвшүүлж байсны зарим нэгийг дурдъя. Эмээлийн хөгөлдрөг хударга, хазаар мэтийн чимхлүүр ур шаардсан чимгийг гагцхүү “цомог” цутгуураар хэвшүүлдэг. Гэтэл эмээлийн арван цагаан хэмээгддэг овортой

биетийг “хавсаг” цутгуураар хэвшүүлж заншжээ. Ийм хэвшүүлэх аргыг боржигон урчууд голцуу “нэрмэл” цутгуур гэж хэлдэг тохиолдол ч бий. Тожилын хавсаг цутгуураар хэвшүүлсэн даруулгад дугуй, давхар дугуй, эсвэл дөрвөлж, нүдтэй дөрвөлжөө нүдэвч багажаар цохиж цоолборлохын зэрэгт эвэр угалзаа цавчуураар эсгэж гөрмөл хүрээ тавьж хажсан харагддаг. Үнэндээ эмээлийн тоног сэлт бол дүрслэлийн хувьд чимэг ажиллаварын тоглоолоор уншигддаг өвөрмөц хэлтэй бөгөөд урын боловсрууллаараа тэс өөр шийдэлтэй байдаг. Тожил дархан тоног даруулгын чагтан сүлжээ оруулгыг оворшуулан цутгаж, ташиж цоолборлосон нь чимэгт сүр өгөх агаад хээний нуруу эргэлэгийг үрлэн хажаар гурвилаж, эвэр угалзны толгойг сөхөн тэвшүүрдэж, хумс цохилгоор нүдлэн суулгасан уран чадмаг заслага тэргүүтэн нь эмээлийн тоног сэлтийг гоёмсог дэгжин харагдуулдаг төдийгүй дүрслэлийн давтагдашгүй хэв маягийг тодруулдаг. Ялангуяа “хүрээ хаж” гэхэд дүрслэх талбайг хээ зурлагаас ялган тусгаарлахын сацуу чимэглэх хэллэгтэй болгодог. “Үрлэн хаж” нь хээний товгор ирмэгийг эмхэрдэж сүлжээний оруулга зурлагын хөдөлгөөнийг тодотгосон тоглоол болж өгдөгөөрөө гоц. Хээ зурлагын амин элемент болох төрөл бүрийн “хаж” өөрөө хөдөлгөөн, сүлжээс, дагнаас, горви мэтийг нэгийг нөгөөгөөс ялган чимдэг мэт боловч дүрслэлийн хувьдаа ингэмэлийн техстур бичлэгийн даралт ширвэлтийг тасалдуулалгүй гаргаж илэрхийлдэг чадварыг дархан хүнээс нэхдэг ёстой нэг ур учир монгол дархны урлалд ихэд дэлгэрч эдүгээ хүртэл уламжлагдан үлджээ.

“Хүрд” бүтээгч гэдгээрээ Цэцэн ханы хүрээнд алдаршсан Лувсандагзангийн (Сэцэн вангийн хошуу) цутгасан “Сургаал хүрд” хорлыг ур утгын хувьд дурьдахгүй өнгөрч боломгүй байна. Түүний урласан хорло дүрслэлд үл ялагдах мянган хигээст өгүүлэгдэх бөгөөд ялангуяа алтан хорло (хүрд) нь халдах аливаа буруу номтоныг тариний хүчээр дарах сэнс байх увидасыг шингээдгээрээ тун утга начиртай. Хорло шид гэтэлгэх хүчний хувьд арван зүгт яруу сонсогдох цагаан лавай, хамаг хүслэн төгс дуусахгүй ариун аршаан агуулах эрдэнийн бумба, ухаан задлаж дуусаж төгсөхгүй жаргалын өлзий утас зэрэг өлзийт найман тэмдэг (Дашдагжид) гэсэн нууц тариний номоос эхтэй. Тэрбээр мөнгөөр хорол цутгахдаа Батноровыхны баримталдаг хөндий цутгуурын аргаар үйлдэж, бадамын арван зургаан дэлбээг цул мөртөө тал товгор овор эзлэхүүн бүхий бат бөх эвдэршгүй суурьтай авч түүн дээрээ найман тахилыг сүлжээ угалзтай хослуулан битүү шигэж урласан нь ерөнхий хэлбэрээ чантамуни зохиомжтой аж. Манай үндэсний гоёл чимэглэлийн урлалын санд нутагшин үлдсэн уг бүтээлийг чимэглэхдээ зориулалтанд нь тохируулан заавал зөн бэлгэдлийн утга санаа оруулсан бөгөөд найралдаж зохицоогүй дүрс үгүй, бараг нэг ч зай завсаргүй өгөөмөр баялаг хээлсэн нь дорно дахины таринийн шидийг гайхуулжээ. Чантамуни хэлбэр нь далайд байдаг үнэт ховор чулуу буюу аливаа хорлолтой муу юмыг үл нэвтрүүлэх шид бүхий эрдэнэ тул хамаг хүслэн сэтгэгчлэн бүтэх ерөөлтэй. Харин хорол бүгдийг бадам цэцгээр суурилдаг нь орчлонд төрсөн хэдий ч орчлонгоос хэтийддэг гэгээрлийг олсныг бэлгэдэн балчгийн бузрыг авалгүй ариун байдаг гэх санаа дээдлэгддэг. Угтаа сүсэгтэн бүхний мэддэг “Ом ма ни бад мэ хум” уншлага нь бадам цэцэг дээр сувд эрдэнэ байна гэх утгатай буюу лянхуа цэцгээс төрсөн эрдэнэ (бурхан багш) мандах болтугай гэсэн тэмдэг байдаг. Бөгтөр дархан эрэг шурагтай, хөдөлгүүр бүхий дуу уншлага гаргадаг шүтээний зүйл урласны дотор ногоон дарь эхийн зүрхэн тарнийг дөчин хоёр дахин уншуулдаг “хүрд” бүтээсэн сураг ч бий. Энэ бүхнээс үзэхэд бурхан шашины урлалын зүйлийг монгол дархцуул Энэтхэг, Түвдийн мэдлэг ухааныг хуулбарлах төдий

төмөрлөгийн урлалд буулгасан бус харин дархан бүр өөр өөрийн ур чадлаа гайхуулах гэхдээ номын ёсоор бүтээдэг байсныг тэмдэглэх нь зүйтэй (Зураг 4).




Зураг 4.

1. Лувсандагзан. Сургаал
хүрд, мөнгө
2. Алтан хорло. XVIII зуун.
өндөр-Н 64 см, Dm 24 см,
Хархорин, Эрдэнэзуу.
Inv.-Nr.65-1162

Урчууд эмээлээ чимэглэхдээ иж бүрдлээр, хазаарын шанаавч хос зангилаа, хамравч сурны тэхий голд буй товруунд нүдэн угалзыг, сагалдаргны сэжимд явган хээ суулгаж, сурыг бүхэлд нь цувьсан гурвиар бөгжилдөг. Хазаарын шагайнд багвар чимэг цутгаж, зуузайг жийжүүдэх, эсвэл зувцаалах аргаар үйлдэнэ. Худраганы зангилаа бүрээ товруугаар суулган нуруувч, ууцавчийг дагуулан цутгамал голцуу угалзаар гурвилж урлах нь түгээмэл билээ. Үүнийг зарим судлаачид Хар Түдэвийх гэх тал байна. Эл хазаарын чимгийг урын талаас шинжвэл, хэрэглээг хээ дүрсийн маягт тохируулсан хэдэн янзын хийцийг сонгон сонгон дархлаажээ. Нэгд гэвэл, тоног тус бүрийн хэлбэрт урыг шингээхдээ ажиллавараа цогцоор шийдсэн байна. Нэрлэбэл, сагалдаргны тээг, зангилааны товруу, зуузайны уулзварын хүрээг үрлэн хажаар гурвилсан байхад эвэр, хамар угалз, болоод өлзий чагтыг сүлжээний оруулгын дагуу гүйлгүүр хаж, эргэлэг зүсүүр, нүдэн хумсаар дагнаасласан аж. Хоёрт гэвэл, тоног тус бүрт гол шигтгээг ялгаруулж тодотгохдоо дүрст тэнхлэг, хэмийн байршлыг зохируулсан байна. Ялгаж хэлбэл, тээгд эвэр угалзны эргэлгийг найман нүдэт өлзий чагттай хослуулан удган эрвээхэйг шигтгээ болгосон бол харин товрууд нь таван нүдэт өлзий чагт дээр дөрвөн дэлбээт цэцэг шигтгэсэн байгаа юм. Энд нэлээн онцлох зүйл бол өлзий чагтаа наймт, тавтын алтан дундачийн тоон харьцаагаар сонгосон нь чимгийг нэн уртай, харагдахуйц маягтай болгожээ. Хэрэв Тожилын хийцтэй Хар Түдэвийн дэгийг зүйрлэбэл, өөр хоорондоо тэс ангид чадвар нэхсэн барилтай байдаг. Тожилынх хээний зохицол, хэмийн байршил маш энгийн бөгөөд үзүүлэх зүйлээ тэх голд нь буюу хүрээнд таслан томоор авч нуруулгүй товчоолдог. Тэгвэл, Түдэвийнх дүрсийн зохиомж, хэм хэмнэлийн хослол яруу байхын сацуу нэн тэргүүнд гол шигтгээнд саад болох ямарч илүү хээ дүрс үгүй, зохиомжид гарцаагүй шаардлагатай хийц урыг шилмэлээр гээлгүй үзүүлдэг номтой авай. Батноров хийцийн гар урлалд хэвшсэн хээ угалзыг ажиглахад алт, мөнгө, ган, төмрийн хөөмөл, цоолтвор зэргийг чимэглэх эдийн галбир онцлогт тохируулсан төрөл бүрийн дүрс, тэнхлэг, хэм хэмжээ, хөдөлгөөн, сүлжээ, хаж, самнаа, дагнаастай дархладагаар гаргууд байсан гэмээр. Оросын нэрт уран зураач Николай

Рерих “Угалзлаж сүлжихдээ төрлөхийн авъяастай монголчуудын уран сайхан бүтээлийг харсан хэн бүхэн, ер нь хүн хичнээн гайхамаар зүйлсийг бүтээж болдгийг та хараад аяндаа ойлгох учраас энэ тухай дурьдахад ч илүүдмээр байна.”⁵ гэсэн нь ур хийцийг магадлах нэгэн сэжүүртөдийгүй гоёл чимэглэл гэж юуг хэлээд буйг сэтгэлдээ мэдэрснийх буй заа (Зураг 5).



Зураг 5.

1. Тожил. Хазаар, мөнгө.
(Батноров хийц)

2. Хар Түдэв. Хазаар, мөнгө.
(Батноров хийц)
SCM D-4030 und 4031.


Батноровын дархчуулаас илт ялгагдах дүрслэлийн хэв маяг бол утсан сүлжмэлээр үйлдсэн мөнгөн эдлэлийн Дарьганга хийц юм. Уг хийцэд шаваг мөнгөөр нүдэн өлзий, эвэр угалз, цэцэг навч дүрслэж түүнийгээ бусад чимэг сэлтгэй сүлжихэд хаж горвилох барил чухал. Энэ утгаараа шавандсан мөнгөн утсан хээний чимгээс хажыг зааглаж тайлбарлахын аргагүй. Гоёо чимгийн хувьд утсан сүлжмэл хийц өөрөө хажих үйлдэл, үрлэн буюу хөвөөлөх үйлдэлтэй хослосноор ур дүрслэлийг үүсгэдэг. Уламжлалт барилаараа шавандаж хөвөөлөх хээний сүлжээ хавсрага (туслах) шинжтэй байхад, нэлээд хожим Дарьганга барилд хаж нь бие даасан шинжтэй чимэглэлийн элемент болтлоо хувьсчээ. Эл хувьсал Хятан нар алт мөнгөний урлалд “хөвөөл” (пектроль) бүхий утас сүлжсэн чимгээр их дэлгэрсэн бөгөөд “Их Юаний үеийн эхнэр хүний гоёлын зориулалтад хэрэглэгдэж”⁶ байсан гэх мэдээтэй холбогдож байна. Түүхэн үүднээс утсан сүлжмэлийн урлалыг Марк Крамаровский “Алтан ордныхны филигранны тухай асуудалд”⁷ гэсэн судлагаанд багагүй тайлбарлал хийсэн нь Дарьганга хийцийг ялгаж тодруулахад яалт ч үгүй сурвалж болж буй. Дарьганга хийцийг ажиглахад шавандсан утсан хээг хоёр янзын арга барилаар үйлдэж байсан нь илэрхий байдаг. Юуны өмнө шаваг мөнгөө хээний цооллогын дагуу өөр хооронд нь холбож “хөндий”

⁵ Рерих Николай (1975. 152) Зажигайте сердца. М.,

⁶ Wen-wu (1992. 37-51) Cultural Relics. n12.,

⁷ Крамаровский М.Г. (2001. 169-185) Золото Чингисидов: культурное наследие Золотой Орды. С-Пб.,

гагнадаг нэг онцлог байхад, нөгөө нь мөнгөн ялтсанд цооллогоо тортогдоод ормоор нь утсан эрчлээстээ цулгүй хаж барьж “давхар” гагнах өөр нэг онцлогтой. Аль аль барил нь дарьгангын утсан сүлжмэлд өвлөж эхнэр хүний толгойн боолтын гоёл чимэгт хэрэглэдэг боловч хээн гол ур, шийдлүүд үндсэндээ цооллогын загвар бүтцэд хадгалагдан үлдсэнийг ажиглаж болно. Энд тайлбарлагдах зайлшгүй хийц ур нь цооллогод бий. Сонгосон хээг гар үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд эх загвар нь цооллого болдогоороо сонирхол татаж байна (Зураг 6).



Зураг 6. Нямын Шаравжамц. Дарьгангын эхнэр хүний толгойн боолтын “цооллого” загвар

Цооллогыг нимгэн элдсэн сарьсан дээр үйлдэхдээ гол төлөв хоёр, дөрөв, найм таллан нугалаад, тэрхүү нугалбарт дүрсээ тиглэж загварыг эсгэж хийдэг. Тодруулбал, тортогдох хээний хэмжээндээ сарьс буюу цаасаа тохируулж хувилах дүрсээс хамаарч хэд нуглахыг шийднэ гэсэн үг. Чухамдаа шаваг мөнгөөр үйлдэх загварыг Дарьганга дархчууд тэр болгон зохиодоггүй бөгөөд нэртэй дархчуулын загвараас эх авах, эсвэл дуурайх явдал байсан гэж хууччуул ярьдаг нь оргүй үг бишээ. Цооллого үлгэрүүд төрөлсөх тутам ажиллавар нарийсаж дархчуудын арга барил ялгарч ирсэн байдаг. Хуучин Дарьганга сүргийн баруун адуучны Нямын Шаравжамц дархан бүхий л үйлээ бодолцсоноо ур хийцтэйг загвар болгож бүтээхдээ гаргууд байсан нэгэн. Тэрээр цооллого загвар гаргахдаа ганцхан урыг тэтгэсэнгүй, хэд хичнээн лан мөнгө орох, хэдүй хэрий хугацаатай дархлах зэргийг хамтад нь шийддэг байсан гэх баримт бий. Ц.Гочоогийн эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэлд “1910-аад оны үед

Шаравжамц, мөн Асгат сумын дархан Сэнгэдаа нарын гаргасан загвараар биечлэн гагцхүү энэ тогтыг хийхэд 4 тал өдөр буюу 38 цагийн хугацаанд 3 лан 6 цэн мөнгөөр хийдэг байжээ”⁸ гэсэн байна. Энэ баримт нь тэд чимэглэх зүйлийнхээ зориулалт нөхцөлийг анхаараад зогссонгүй хэлбэр байдлын онцлогт хээ угалзыг зохируулснаа эсгүүр цооллогт баримталдаг байсан нь ойлгогдож байна. Цооллого эсгүүрийг ажиглахад, ирмэг захаар богино эвэр угалзан хээг давтсан хэмнэл гарган цувуулан тавьжээ. Шивэрлэг, нарийн татуурга мэтэд тэр давталт нь дөрвөлж талт нүдэн өлзийтэй хоршиж уран тансаг хэмнэл үүсгэнэ. Түүнчлэн тал эсгүүрт шигтгээг суулгахдаа тэгш хэмийн зарчмыг ёсочлон шивэрлэгийн булан тохойд шигтгээг бүтнээр авсан хэрнээ нугалбар тэнхлэгийн дагуух шигтгээг хугаслан цувуулж цоолборложээ. Шаравжамцын цооллого нь цувмал утсаа нэг бол шууд хээлэх, үгүй бол цувмал утсаа хажиж байж хээлэх зэрэг давтагдмал бус хийцийг хэрэглэсэн нь аргагүй том дархны ур орсны шинж мөн билээ.

Дарьганга сүргийн дархчуул шигтгээний хэлбэр хийгээд хүрээлэх чимгийг цооллгоороо нэг нэгээсээ ялгагдагаас “салга” Амангаагийн, “бөгтөр” Балдангийн, “бөгөөн” Самдангийн, “хөнхөр” Дамдингийн, “балтага” Содовын, “лхажаа” Лхамсүрэнгийн, “дүлий” Гомбосүрэнгийн хийц гэхчилэн нэрлэгдэж иржээ. Тэгээд ч чимэглэх эдийн төрхөд тааруулж шигтгээг дугуй, тал сар, дөрвөлж, гонзгой, зууван хэлбэрээр засаж зохилдлоготой хувилбараар байрлуулдаг төдийгүй нэг хэсэг нь шигтгээг хумсаар даруулж, нөгөө хэсэг нь хүрээлэн хажиж, зарим нь нааж хүртэл тогтоодог аргатайгаас өөр өөр маягтай харагддаг болой. Эхнэр хүний толгойн боолтны зохилдлогот маяг ямар төрхөөр галбиршихад тоо хэмжээ чухал үүрэгтэй. Тухайлбал, Дарьганга дархчуул толгойн боолтын шигтгээг 4, 8, 16, 32, 64 зэрэг үелэл давтамжаар хэрэглэж ирсэн бөгөөд түүнийг санааны дур зоргоор сонгож байсангүй зөвхөн цооллогын нугалбар хэм тэгшрэх эрэмбийг баримтлан үйлдэх тул загвар үйлдэгч тэр бүгдийг ерөөл дэлгэрэх санаагаар ёсочлодог. Чимгийн байрлал донжид шигтгээ зохицож байдгийг дарьгангын аль ч хийцээс ажиглаж болох авч шигтгээний хэлбэр нь эмэгтэй хүний гоёмсог хээнцэр төрхийг тодруулаад зогсохгүй бэл бинчинг харуулах өгүүлэгч нь болдог. Тэдгээрээс дархны урыг харахаас илүүтэй Дарьганга эхнэр хүнийг тансаг гоёл ямар үзэсгэлэнтэй болгодгийг мэдрүүлдэг. Шаваг мөнгөөр угалз сүлжин шүрэн хондоор гэгээ татмаар урладаг нь дархан хүн юутай гайхалтай зүйлийг бүтээж чаддагийг илтгэх нь гарцаагүй (Зураг 7).

Тэрхүү чимэг сэлтээр хүүхэн хүний царай зүсний үлэмж сайхныг мэдрүүлдэг нь толгойн боолтын шигтгээтэй үнэнхүү хосолдогтоо юм. Үүнд толгойн боолтыг бүтээсэн хээ угалзны сүлжээс, эргэлэг, хөдөлгөөний шилжүүлэг, тэгш хэмийн тусгал хэрхэн зохицох хувилбарт тодорхой шигтгээний дагнаас хүртэл зайлшгүй яригдана. Толгойн боолтын гоёо сэлтийн байршил тэнцвэрийг ажиглахад, нугалбар хээний анхлах зурлага



Зураг 7.

Дарьганга эхнэрийн толгойн боолт: алтан шармал, мөнгө, шүр

⁸ Гоцоо Ц. (2003.70) Эрдэм шинжилгээний өгүүлэлүүд. УБ.,


(сэдэл) хийцээ шууд харагдуулдаггүй. Чухамдаа хээ тигшрэх нугалбар хэмнэлүүд шигтгээний байршлыг тодотгож байж сая иж бүрдлээр хийц харагдахуйц болдог. Энэ нь ямар хэлбэртэй шигтгээнд хээ угалзаа хэрхэн зохируулж чаддаг чадвартай байсныг илтгэсэн нэг л жишээ. Дархчууд, хээ угалзны хэлбэр шигтгээ чимгээр наадахын зэрэгцээ мөнгөн эдлэлээ алтаар шарж “шунх”, “хонд” шүр тэргүүтнээр өнгө яруусдаг нь харахад үзэмжтэй төдийгүй хэний ч нүдийг хужирлахуйц маягтай гэж үзүүштэй. Тухайлбал, ухаа улаан өнгийн шүрэн дагнаасыг “нариу шүр” гэж, хүрэн улаан өнгийн шүрэн дагнаасыг “линс шүр” гэх мэтээр нэрлэдэг ч тал нутгийнхны үлэмжийн сайхныг оноох ойлголттой ямар нэг хэмжээгээр шүтэлцдэг байна. Эдлэлээ алтлаг дэвсгэрт есөн эрдэнийн өнгөөр суулгаж, чулууны гэрэлтэх талстыг шигтгэж, төрөл бүрийн хээ хажаар нарийн ур ажиллавартай үйлдсэн нь үзэмжийг хосгүй илэрхийлэлтэй болгодог шинжтэй. Энэчлэн мөнгөн шавгаар угалз мэтгэж, шигтгээг дагнаж тигшитгэхдээ цоолог хээний сонголтоо аль болох даруу атлаа эрхэм дүрслэлтэй болгодогт дарьгангын хийц ялгарна.

Дарьгангын дархчуулын хийц дүрслэлийн угт алтаар шармалдах горимд ч бас нууцлагддаг. Хоргол алтаар, эсвэл шижир алтаа маш нимгэлж давтаад, улмаар хигэж зарим тохиолдолд торгон элстэй нунтаглан зайлж боловсруулахдаа тэд гаргууд. Элстэй хольж зайлахын учир бол алтыг цэвэршүүлж тунгаахад хэрэглэдэг гол арга бөгөөд тэр нь мөнгөн усанд хануулж идүүлэхээс дутахааргүй жор найрлагатай билээ. Ингэж цэвэршүүлсэн алтны зохист найрлага бүрэлдвээс шармалдсан эдийн өнгө туяарна, найрлага эс тохирвоос алтны өнгө ногоорч шармалдах боломжгүй болдог. Тухайн найрлага жор нь мөнгөн эдээ байванд буцалгаж алтдах хэсгийг “чацарганы тос буюу донга үрийн уусмал (донга гэж халуун орны ургамал)”⁹ түрхэж, улмаар жигд халааж мөнгөн усаар ууршуулж шармалдах горимтой дүйнэ. Дарьгангын дархчууд гоёо ураа битүү шармалдаж бүрэхдээ нэг бол алтаар түрхэж шармалдаж, үгүй бол хэсэгчлэн булхуулж алтаддаг. Сэнгэдаагийн хийцэд шармалдах өлзий, жирмэн сүлжээ мэт хээ, тэдгээрийн нугалбар үелэлийг нүдлэж алтаддаг ур голлодог. “Бага шар” хэмээгдэх Ш.Дүйнхэр дархан гурван зуун цаасан загвар хийснээс аяганых гэхэд зуу хол давсан нь ч гэсэн яриа байдаг. “Бага шар” дархан нь гөрмөл сүлжээг дагнан эмхэлж улмаар эргэлэгийг “удган” сөргүүлж давтсан төв маягийн энгийн хийцийг бий болгожээ. Дарьганга хийцийн мөнгөлсөн аяганы тухайд Л.Сономцэрэн “амсарт дөрвөлж буюу бөөрөнхий зээг тавьж гагнадаг. Уул арга Дарьгангад их тархсан байна”¹⁰ гэдгийг тэмдэглэн үлдээжээ. Бага Шарын хийцийг бусдаас ялган таних ур бол хүнхээгээ жирмэн сүлжээсээр битүү ороож, аяганы хишигтэд дүрслэх урлагт багагүй хэрэглэдэг амьтны сүр хүчээр хүний сэтгэмжийн мөн чанарыг үзүүлсэн загвар нь буй. Тэрээр сүлжээс тус бүрийн адагт 48, 64 нүдэн товруугаар давтамжтай шийдэж, иргэдийнх шиг хээ чимэг ихтэй бус нүүдэл даахад тохирсон бат бөх хийцтэй. Бага шараар алдаршсан Дүйнхор дархан маань зээг хаж гүйлгэн гагнах урыг өөрөөр нь дүрслэх элемент болгож, сүлжээг эрчлээсээр хөврүүлж хээ болгон хөгжүүлсэн юм. Хамгийн гол нь цулгүй хажны гурви дотуур сувимал утас гүйлгэн гагнаж улмаар жирмэн хээг эрэглэгтэй сүлжсэнээ торгон самнаа эгшээж гагнаад сүлжээний адагт молцог тав шигтгэн эргүүлж гагнахаас гадна хүрээгээр нь нүдэн товруу үелэн цувуулж гагнаснаар хүнхээний

⁹ Сономцэрэн Л. (1989. 48) Монгол ардын уламжлалт урлагийн дурсгал. УБ.,

¹⁰ Сономцэрэн Л. (1989. 73) Монгол ардын уламжлалт урлагийн дурсгал. УБ.,

галбирыг үүтгэдэг. Нэгэн төрлийн сүлжээ хээг гагнуураар галбиршуулах “нүдтэй” Дүйнхорын ур дүрслэл нь давтамжаа хэсэглэл үгүй зөвхөн эргэлэгийн дагуу хөдөлгөөний чиглэлээр эрчтэйгээс эрчтэй хэмнэл бүхий “гөрж” илэрхийлсэн байдаг. Ийм энгийн дүрслэлтэй, жигд давтамжтай үлэмж тогтуун ерөнхийлөлтэй хийц ганцхан мань дархны аяганы ураас уншигддаг. Дээр өгүүлснээс үзэхүл, бага шар дархны мөнгөлсөн аяга нь хэрэглээг бодолцож аль болохоор товч төв хэллэгтэй урласнаараа ялгагдана. Аяганы ийм ур дүрслэлд чимэг хээний гагцхүү хөдөлгөөн, хэмнэл, эргэлтийг тодотгосон хүрээ хаж зонхилсон хосгүй үзэмжийг таниулдаг өвөрмөц барилтайг харж болно (Зураг 8).



Зураг 8.

1. Бага шар. Мөнгөн аяганы цооллого загвар.
2. Аяганы хишигний амьтны цооллого дүрс. мөнгөн хөөмөл
3. Мөнгөн аяга. (Дарьганга хийц) Дүрслэх урлагийн музей.

Манай монгол дархчуул хар ган (цэвэр) болоод хөх ганг (зөөлөн) элдэв барилаар сийлж хэрэглээний зүйлс хийдэг арвин туршлагатай байсны дотор Далайчойнхорын дэг үнэнхүү судлууштай зүйл. Хэдийгээр ган сийлбэрийн урыг цоолбор, хөндий, хавтгай, ингэмэл гэж ялгамжтай нэрлэдэг ч гэлээ хээ чимгийг сийлж алтаар зувцаадаж, мөнгөөр жийжүүддэг нь яах ч аргагүй Далайчойнхорынхны шийдэлд уламжлагдсаныг ихэнх судлаачид хүлээн зөвшөөрдөг. Бидний судласнаар ганг сийлэхдээ нэвт цоолдог нь тийм ч чухал зүйл биш. Харин бэлийн толгойд зээ бадь, хацарт арслан, дэвсгэрт эвэр хээ, уялга угалз, цэцэг үр наадуулан орон зай олон янз хэмжээст дүрсэлсэн нь Сайнноён хан аймгийн дархчуулыг тодотгох гол онцлогтой юм. Ялангуяа ганг сийлбэрлэх ур чадлаараа хамгийн нэрд гарсан дархчуул гэж хуучны Далайчойнхор вангийн хошуугаар овоглосон Гомпилын Ерэнтэй, “Хөгз” Аюуш, “Цагаан” хэмээх Гэндэн, Самбуу (дүү нь), “Чавганц” Жамбал, “Цоохор” Лхамсүрэн, “Нүцгэн” Лханаажав, “жанжаа” Жамсран, “Буурал” Наянтай, “Шалчаан” Ёндонжамцыг нэрлэж болно. Ган сийлбэрчдийн дундаас “Цагаан” хэмээн авгайлагдсан Самбуугийн Дүрслэх урлагийн музейн сан хөмрөгт буй ган хэт хутга цууд гарчээ. Түүний урласан амьтны загварт урлалд ёгт санааг хэлбэртэй нь хослуулж, донжийг өөр өөр байрлал маягтай дүрсэлсэн байна. Тэрбээр хээ чимгийг хэд хэдэн давхар сийлбэрлэхийн тулд Батноровынх шиг цутгуур бэлдэлгүй шивүүр загвараа барьж хөндий байх гол хэсгийг өмлөн ухахдаа зөөлөн ганг бэлдгэх зуршилтай нь хийцээс ажиглагддаг. Зөөлөн ганг хүрэн улаан өнгө туяартал уяраагаад хөөргөний халуун нурманд булж “битүү” (салхи авахуулалгүй) хөргөсний дараа л дархлах (сийлэх) ажлаа гүйцэлдүүлдэг байсан гэлцдэг. Угтаа сийлбэр нь ухах, өм нүхлэхээс эхэлдэг ёстой. Эх галбирыг сийлүүрээр өмлөхдөө гурван хэмжээстийн битүү цул байх хэсэг,

хөндий байх хэсэг хоёрын харгалдах орон зайн шийдлийг дархчуул голцуу “өм нүх” гэж ойлгодог. Түүний урласан бэлний толгой, хацар, нугас, горхи тэргүүтэн нь бусад Далайчойнхорын дэгээс тун өвөрмөц. Учир юун гэвэл, бэлийг ингэмэл мэт сийлэлгүй дүрсээ олон төрөл ажиллавар бүхий хагас товгор, бүтэн оворт, бас хөндий ухалтаар сүлэлдүүлж үйлддэгтээ илт содон харагддаг. Бэл толгойг “зээ бад”-аар төвлөж, хажуу дэвсгэрийг эвэр угалзаар тэгш хэмтэйгээр ухахдаа орон зайн болоод дүрсийн элементийг өвөр хооронд нь цэгцтэй галбиршуулсан нь түүний барилын нэг онцлог. Тэр тусмаа зээ бадын дүрсээ бэлний зүүн баруун талаас хамаарч тус тусын шийдэлтэй бүтээсэн байна. Өнгөц харахад ижилдүү мэт санагдавч угтаа бэлний хацар дахь арслангийн төрх нэг нь нөгөөгөө давтаагүй нь бүр ч гайхалтай. Тодруулбал зүүн талынх буюу хутганы бэл, хацар дээрхи хүрээнд доог хийх мэт арсланг нугдайлан хажуудуулсан бол нөгөө баруун талыг буюу хэтний бэл, хацар дээрхи сүүлээ шарваж буй арсланг эгцдүү харуулж сийлжээ. Бэлний толгой, хацар сэлтийг холбосон нугасыг сольбиж тавласангүй. Харин бэл хацарт суурилсан горви тээгээ толгой бэлний чихтэй сүлбэж оньсолжээ. Тэгэхдээ хашлага, толгойн чимэгт саад болохгүйгээр цулгүй гархиж урласан нь аргагүй л дархан хүн хийх ур гэлтэй. Чухамдаа арслан хийгээд зээбадын дүрслэлийн ёгт егөө байдлыг донжтой харуулж сийлсэн ч монгол дархны өвөөс улбаатай. Бүр хүрлийн урлалын тэртээгээс амьтны төрхийг элдэв галбарт сэлгэж хэмжээ харьцааг давхар бодолцсон байдаг. Хүчтэн амьтан болгосон “гаж” төрхийг хөдөлгөөнтэй нь хослуулахдаа үлэмж гаргууд байсныг хийцийн онцлогоос харагддаг. (Зураг 9).



Зураг 9. “Цагаан” Самбуу. Хэт хутга, бэл. (ган) Дүрслэх урлагийн музей

Ялангуяа ган сийлбэрийн нүдний ураар хэнийг ч дагуулахгүй нэгэн “алтан” гартан бол Ерэнтэй байсныг, түүний “ган бэл” ямар хосгүй чимэгтэйг задалж тайлбар өгөх шаардлага нэхэгдээд буй билээ. Түүний ур чадал, хийц хэлбэрийн талаар манай ахмад судлаачид багагүй сурвалжилсан бөгөөд “тэр бүгдийг хөндий сийлж урласан нь үнэхээр чадварлаг... дүрсийг урлахдаа түүнд тохирсон амьтан, хээ угалзыг эдийнхээ хэлбэр

байдал, зориулалттай хослуулж чадмаг шийддэг”¹¹ гэж тодотгосон нь, “уран Манжилжав би Ерэнтэй гуайн дэргэд юу ч биш” гэх, “Ерэнтэй гуайг шүтдэг хүний нэг нь Шалчаан дархан билээ”¹² хэмээн учирласан нь, “... Ерэнтэйн дүү Түнтүү, дархан Чавганц Жамбал нартай Богдын хүрээ очиж “Жадамба” судрын бар хийлцээд Г.Ерэнтэй ах хажуу талдаа нохой хөтөлсөн хүний сийлбэртэй сүүж мана хөөргөөр шаглуулсан ...”¹³ гэх баримт мэдээ сонирхол татаж байна.

Ерэнтэйн урласан ган сийлбэр “хэт бэл” Архангай аймгийн музейд байна. Тэрний сийлбэр нь ган дээр хээг сийлэг багажаар хүрээлж сийлдэг аргаас тэс ондоо, гангаа ухаж чимгийг овортой цоолдогоос бүр ч ангид барилаар үйлджээ. Ган сийлэх тэрхүү барилыг зарим судлаачид “бажгар сийлбэр” гэж нэрлэсэн нь ч тохиолдоно. Миний судласнаар бол сийлэх аргыг нь ч бүтээсэн хаалттай зохиомжийг нь ч харгалдуулбал “битүү сийлбэр” гэвэл илүү зохистой нэрлэгдэнэ. Угтаа эл хийц бэлний баруун зүүн тал гэлтгүй усны дусал мэт ижил хээ шилбэ шаглаастай тун чамин эд байдаг. Чамин чаминдаа бэл толгойд цоморлигоо дэлгэж нээгээгүй бадамыг ташуулан мөрлөсөн мөртөө бэл хацар, толгой аль алины заагт цомирлогоо дэлгэсэн удвалыг маш нимгэн сөхөж сийлсэн нь үнэхээр хараа булаам үзэгдэнэ. Хээлэх шилбэний торгон ирмэгийг угалзруулаад түүний зай хооронд үрэл, эвэр, нахиаг далд нуугдуулан тэмтрүүлжээ. Ялангуяа үл ялим, ялимгүй цаашлах угалзны зурлага сийлбэрээ налж ургах лугаа мэтгэсэн нь гангийн чанарыг хэдийнээ амилуулсныг харуулах мэт. Ийм хавтгай ган сийлбэрийг тэр болгон урчууд урлах боломжгүйг тэмдэглүүштэй.

Угалзны ухлаадсыг дотогш үелүүлэн эвэр хумс, үзүүр ухам багажаар сийлж байсныг төсөөлбөл багажны үүрэг нэн чухал байж таарна. Шилбэ эргэлзгийг сөхөж ухахаас аваад дэлбээний ирмэгийг хөндийлөн налуулж мэтгэхэд зориулагдсан багаж зайлшгүй шаардлагатай. Ган сийлбэрт зориулсан эвэр хумсан багаж алхам, толиноосоо шалтгаалж үй олон үйлдэл хийх боломжтой бөгөөд угалзны хүнхээгийг тэгшлэж, дараа нь хумбайлгах бас босгох, налуулж ухах зэрэгт тус тус хэрэглэгддэг. Харин тэвшүүр, цохилуур, хувилуур нь шилбийг мордуулж, гүйлгэж, суулгах гэхчилэн хортонг арилгаж толин өнгөлгөө хийхэд гол үүрэгтэй байдаг. Иймэрхүү нарийн багажаар бэлний уялга сүлжээсийг дан, давхар сийлж чадна. Ган бэлний дэвсгэрт суух хээ, түүнийг нөмрөх дан хээ, бас нүүрэн хэсгийн зурлага хээ бүр нь дархны хүний орон зайн мэдрэмжийг сэдэрэж, улам чимхлүүр “битүү сийлбэрийн” хийц ур нэхдэгийг хэлэх нь зүйтэй. Иймэрхүү битүү сийлэх аргын ялимгүй ялгаа нь бэлний хэлбэр чимгийг яалт ч үгүй үзэсгэлэнтэй харагдуулна. Үүний улмаас угалзны ухлаадас цэвэр, галбир үзэмжтэй, гадарга нимгэрч тодорно. Энэ бүх арга ажиллагааны эцэст л бэл гадарга дээр ур хийц үүсэж галбиршдаг ажээ. Бидний ажиглаж



Зураг 10. Гомтисын Ерэнтэй. Хэт бэл. (ган) XIX зуун

¹¹ Лувсанвандан С. (1982. 60-70) Монголын урлагийн уламжлал шинчлэл. УБ.,

¹² Банзрагч Н. (2000) Халхын Сайн ноён хан аймгийн Далайчойнхор вангийн хошууны түүх. УБ.,

¹³ Зинамидар Б. (2007. 75) Сайн ноён хан аймгийн Далайчойнхор вангийн хошуу, түүний дархчууд. УБ.,

судласнаар ган сийлбэрийн чансаа нь багажаа хэр эзэмшсэн арга ажиллагаанаас хамаарах нь мэдээж. Энэ нь Л.Сономцэрэнгийн “хутга бэл бүхэн дахин давтагдаагүй өөр хээ угалз, дүрсээр чимдэг манай орны шилдэг дархчуулын онцлог болж байжээ” гэснийг санагдуулам аж (зураг 10).

Тухайн дурсгалуудаас үзэхэд XVII -XIX зууны үед бурхан шашны урлахуйн ухааны дэг зонхилож байсны зэрэгцээ өмнө үеүүдээс өвлөсөн сор арга хийцээ уламжлан хадгалж улмаар эдэлгээ хэрэглэгээнд зохицуулан шинэчлэн хялбаршуулж байжээ гэдгийг баримтын зарим сэжим тодотгож буй.

SUMMARY

We as analogists have come to the conclusion that various artistic manner -Mongol Darkhan has three reasons first, the diversity of circumstances of each skill, the second a variety of different styles, in the third, a variety of spiritual types, defining the nature of aesthetic needs and tastes.